



**АВТОТЭЭВРИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ /ТӨҮГ/**

Алтан шар зам тань өлзийтэй байх бэлтгэе

БҮС НУТГИЙН ТЭЭВРИЙН КОРРИДОРУУД, ХУДАЛДАА, ТЭЭВРИЙН ТААЛАМЖИТ НӨХЦЛҮҮД, ХОРИГ СААД, ОЛОН УЛСЫН ТЭЭВРИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦООГ СУДЛАХ

Судалгааны ажлын тайлан

Гүйцэтгэгч:

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ,
Судалгаа, хөгжил чанарын удирдлагын төв



2023 ОН

НЭГ. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	0
1.1 Судалгааны ажлын зорилго:	0
1.2 Үндэслэл хэрэгцээ, шаардлага	0
1.3 Судалгааны хамрах хүрээ:	1
1.4 Судалгааны аргачлал	1
1.5 Мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх	2
ХОЁР. ЗҮҮН ӨМНӨД АЗИЙН ОРНУУДЫН ХОЛБОО (ASEAN)-НЫ УЛСУУДЫН АЧАА ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	2
2.1 Логистикийн салбарын бодлого төлөвлөлт, өнөөгийн байдал.....	3
2.2 Логистик, ачаа тээвэрлэлт гүйцэтгэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт	2
2.2.1 ASEAN-ы гишүүн улсуудын гэрээ, хэлэлцээр	2
2.2.2 Логистикийн үйлчилгээтэй холбоотой дотоодын зохицуулалт	3
2.3 ASEAN-ы ачаа, тээвэрлэлтийн өнөөгийн байдал	4
2.3.1 Гадаад худалдааны тэнцэл, өсөлтийн хувь:.....	4
2.3.2 Экспорт, импортын гол түнш улсууд:.....	5
2.3.3 Экспорт, импортын шилдэг арван бараа, бүтээгдэхүүн:.....	0
2.3.4 Гадаадын шууд хөрөнгө оруулалт /ГШХО/-ын эх үүсвэр:	1
2.4 Логистикийн гүйцэтгэлийн индекс /LPI/.....	2
ГУРАВ. ЗҮҮН ӨМНӨД АЗИЙН ОРНУУДЫН ХОЛБОО (ASEAN)-НЫ УЛСУУДЫН ХАРИЛЦАА, ЭДИЙН ЗАСГИЙН НЭН ТААЛАМЖТАЙ НӨХЦӨЛҮҮД	3
3.1 Гэрээ хэлэлцээрт тусгагдсан зарчим, олгодсон эрх	3
3.2 Транзит тээврийн маршрут, байгууламжийн төлөвлөгөө.....	4
3.3 ASEAN-ы хуурай замын сүлжээ, маршрут	6
ДӨРӨВ. ЗҮҮН ӨМНӨД АЗИЙН ОРНУУДЫН ХОЛБОО (ASEAN)-НЫ УЛСУУДЫН ТЭЭВРИЙН ДЭД БҮТЦИЙН СУДАЛГАА	14
4.1 ASEAN-ы хуурай замын сүлжээ, маршрут	14
ТАВ. ЗҮҮН ӨМНӨД АЗИЙН ОРНУУДЫН ХОЛБОО (ASEAN)-НЫ УЛСУУДЫН ОЛОН УЛСЫН ТЭЭВРИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦОО	20
5.1 “Протокол 5” буюу Автотээврийн хэрэгслийн албан журмын даатгал (хавсралт ...-аас харна уу):.....	20

ГРАФИКАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

График 1. ASEAN-ы бараа бүтээгдэхүүний экспорт, импорт, гадаад худалдааны тэнцэл (тэрбум доллар), 2005-2022	4
График 2. ASEAN-ы гишүүн орнуудын барааны худалдааны өсөлтийн хувь (%).....	5
График 3. Экспорт, гол түнш улсаар, дүнд эзлэх хувь.....	5
График 4. Импорт, гол түнш улсаар, эзлэх хувь	5
График 5. Логистикийн гүйцэтгэлийн индекс /LPI/, улсаар	2
График 6. Вьетнам-Хятад хилийн хаалга	10
График 8. Монгол улстай хийсэн гадаад худалдаа, өртөгөөр /сая.доллар/.....	12
График 9. Монгол улстай хийсэн гадаад худалдааны гүйцэтгэл, хувиар.....	12
График 10. Монгол улстай хийсэн гадаад худалдаа, гишүүн улсаар, өртөгөөр /ам.доллар/	13
График 11. Монгол улстай хийсэн гадаад худалдаа, бараа бүтээгдэхүүний нэр төрлөөр /сая.доллар/.....	13
График 12. Вьетнам-Хятад хилийн хаалга	17

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. ASEAN-ы 2025-ын Мастер төлөвлөгөөний үр дүн ба гаралтын хэмжигдэхүүн	0
Хүснэгт 2. ASEAN-ы арван гишүүн улсын логистикийн үйлчилгээтэй холбоотой дотоодын зохицуулалтууд	3
Хүснэгт 3. Экспортын шилдэг арван бараа, бүтээгдэхүүн	0
Хүснэгт 4. Импортын шилдэг арван бараа, бүтээгдэхүүн.....	1
Хүснэгт 5. Транзит тээврийн маршруудын жагсаалт	4
Хүснэгт 6. Вьетнам-ЛАОС улсын хоорондын хилийн хаалга	8
Хүснэгт 7. Вьетнам-ЛАОС улсын хоорондын хилийн хаалга	15
Хүснэгт 9. Их Меконгийн дэд бүсийн (GMS) үндэстэн дамнасан тээврийн сүлжээ ..	20
Хүснэгт 10. ASEAN-ы зөвлөлийн гишүүдийн даатгалын вэб сайтууд.....	21

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Зүүн Өмнөд Азийн Орнуулын холбооны гишүүн орнууд	2
Зураг 2. ASEAN-ы шилдэг 5 ГШХО эх үүсвэр, 2022 он	1
Зураг 3. ASEAN-ы хуурай замын тээврийн сүлжээ	6
Зураг 4. Авто замаар хил дамнасан тээвэрлэлт	9
Зураг 5. ASEAN-ы газрын тээврийн сүлжээний зураг .. Error! Bookmark not defined.	
Зураг 6. ASEAN-ы хуурай замын тээврийн сүлжээ	14
Зураг 7. Авто замаар хил дамнасан тээвэрлэлт	17
Зураг 8. Хятад-Индохайн хойгийн эдийн засгийн коридор	18
Зураг 9. Хурдны замын сүлжээ	19
Зураг 10. Цэнхэр картны дэлгэрэнгүй мэдээлэл	23
Зураг 11. Онлайнаар тээврийн хэрэгслийн албан журмын даатгал захиалах 5С алхам	23

НЭГ. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1 Судалгааны ажлын зорилго:

1. БНХАУ, ОХУ-тай “Азийн автозамаар тээвэрлэлт гүйцэтгэх тухай” гурван талт хэлэлцээрийг 2016 онд байгуулсан. Хэлэлцээрийг хэрэгжилтийг хангах,
2. “Олон улсын автотээврийн харилцааны тухай” Монгол улсын засгийн газар болон Бүгд найрамдах Хятад Ард улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт хоёр тал 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Бээжин хотноо гарын үсэг зурж, хэлэлцээрийг байгуулсан. “Олон улсын автотээврийн харилцааны тухай” Монгол Улсын засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай МУ-ын ЗТХЯ, БНХАУ-ын Зам тээврийн яам хоорондын протколыг 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр хоёр тал гарын үсэг зурж, баталгаажуулсан. Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлж протоколын хэрэгжилтийг хангах
3. “Олон улсын автотээврийн харилцааны тухай” Монгол улсын засгийн газар, Бүгд найрамдах Хятад Ард улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам, БНХАУ-ын Зам тээврийн яам хоорондын протколыг 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр хоёр тал гарын үсэг зурж, баталгаажуулсан. Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх протоколын хэрэгжилтийг хангах
4. БНХАУ-ын Тяньжин боомтоор дамжин ирэх импортын ачаа тээврийн бөөгнөрөл, ачааллыг бууруулах зорилгоор өөр боомт, тээврийн коридоруудыг бий болгох, хувилбарт гарцын талаар санал боловсруулах, зөвлөмж гаргах,

1.2 Үндэслэл хэрэгцээ, шаардлага

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 4 дүгээр зүйл эдийн засгийн хөгжлийн бодлогын зорилт 4.1.16-д “Дамжин өнгөрүүлэх тээвэр, худалдаа, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг тээвэр логистик, хилийн дэд бүтцийн хамт байгуулан эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангана” гэж, 4.1.26-д “Байгальд ээлтэй, хаягдал багатай, үр ашигтай, хэмнэлттэй эдийн засгийн бүтцийг бий болгох бодлого баримтлана” гэж, 4.2-д Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг хөгжүүлнэ” гэж, 4.2.1. “Нэмүү өртөг шингээсэн уул уурхай, стратегийн мега төслүүд, боловсруулах аж үйлдвэр, хөдөө аж ахуй, эрчим хүч, тээвэр, логистик, төрөлжсөн аялал жуулчлал, түүнийг дагасан үйлчилгээ, жижиг, дунд үйлдвэрлэл, мэдлэгжсэн бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.” Гэж, 6 дугаар зүйл Ногоон хөгжлийн бодлогын 6.4-д “Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна” гэж мөн бодлогын бичиг баримтын 9 дүгээр зүйл Хот төлөвлөлтийн бодлогын зорилт 9.2-д “Иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно”, “Байгальд ээлтэй, дэвшилтэд техник технологи нэвтрүүлэн бохирдол үүсгэгчийг бууруулсан байна” гэсэн зорилтууд тусгагдсан.

1.3 Судалгааны хамрах хүрээ:

Энэхүү судалгаа нь ASEAN-ы бүс нутаг болон түүний гишүүн 10 орон


Region	Улс орнууд
ASEAN	10 ASEAN (Brunei, Cambodia, Philippines, Indonesia, LAOS, Malaysia, Myanmar, Singapore, Thailand, Vietnam)



1.4 Судалгааны аргачлал

Баримт бичгийн шинжилгээ нь тухайн сэдвийн хүрээн дэх судлагдсан байдал, дүрэм журам, хөтөлбөр, тогтоол шийдвэр, өмнөх тайлан мэдээ, үр дүнг харьцуулан судлах боломжийг олгодог давуу талтай.

Схем 1. Баримт бичгийн судалгаа хийх арга зүй




Баримт бичгийн шинжилгээг хоёрдогч эх үүсвэрийг ашиглан дараах баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

- OECD Competition Assessment Reviews: Logistics Sector in ASEAN
- Дамжин өнгөрөх тээвэрлэлтийг хөнгөвчлөх тухай суурь хэлэлцээр
- ASEAN Key Figures 2023
- ASEAN statistical yearbook 2023
- Master plan on asean connectivity 2025

1.5 Мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх

Бид ашиглаж буй судалгааны аргаас хамааруулан дараах програм хангамжийг ашиглан судалгааны тайланг боловсруулсан.



Мэдээлэл оруулах,
шивэлтийн алдааг
шалгах


Мэдээлэл
боловсруулах дүн
шинжилгээ хийх

Тайлан
боловсруулах

ХОЁР. ЗҮҮН ӨМНӨД АЗИЙН ОРНУУДЫН ХОЛБОО (ASEAN)-НЫ УЛСУУДЫН АЧАА ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Зүүн өмнөд азийн орнуудын холбоо болох ASEAN-г 1967 онд Индонез, Тайланд, Сингапур, Малайз, Филиппиний гадаад хэргийн сайд нарын хурлаар үндэслэн байгуулсан. 1984 онд Бруней, 1995 онд Вьетнам, 1997 онд Лаос, Мянма, 1999 онди Комбож тус тус гишүүн болсон байна.

Зураг 1. Зүүн Өмнөд Азийн Орнуулын холбооны гишүүн орнууд



ASEAN-ы тунхаглалд дурдсанчлан ASEAN-ы зорилго, зорилтууд нь:

- Зүүн өмнөд Азийн үндэстнүүдийн чинээлэг, энх тайван хамтын нийгэмлэгийн үндэс суурийг бэхжүүлэхийн тулд эрх тэгш байдал, түншлэлийн үзэл санааны хүрээнд хамтын хүчин чармайлтаар бүс нутгийн эдийн засгийн өсөлт, нийгмийн дэвшил, соёлын хөгжлийг хурдасгах;

- Бүс нутгийн улс орнуудын хоорондын харилцаанд шударга ёс, хууль дээдлэх ёсыг дээдлэн, НҮБ-ын дүрмийн зарчмуудыг баримтлах замаар бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг дэмжих;
- Эдийн засаг, нийгэм, соёл, техник, шинжлэх ухаан, захиргааны салбарт нийтлэг ашиг сонирхолд нийцсэн асуудлаар идэвхтэй хамтын ажиллагаа, харилцан туслалцааг дэмжих;
- Боловсрол, мэргэжил, техникийн болон захиргааны чиглэлээр сургалт, судалгааны бааз хэлбэрээр харилцан туслалцаа үзүүлэх;
- Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, худалдааны салбарын цаашдын өсөлтийг дэмжихийн тулд илүү үр дүнтэй хамтран ажиллана. Үүнд ASEAN-ы ард түмний амьжиргааны түвшинг дээшлүүлэх үндсэн зорилго бүхий тээвэр, харилцаа холбооны хэрэгслийг сайжруулах, олон улсын түүхий эдийн худалдааны талаар судалгаа хийх;
- Зүүн өмнөд Азийн судалгааг сурталчлах;
- Ижил төстэй зорилготой олон улсын болон бүс нутгийн байгууллагуудтай нягт, үр өгөөжтэй хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, өөр хоорондоо илүү нягт хамтран ажиллах бүх арга замыг эрэлхийлнэ.

2.1 Логистикийн салбарын бодлого төлөвлөлт, өнөөгийн байдал

ASEAN нь гадаад түншүүд болох Хятад, Солонгос, Япон, Энэтхэг, Австрали, Шинэ Зеланд зэрэг улс орнуудтай чөлөөт худалдааны төрөл бүрийн гэрээ байгуулснаар сүүлийн арван жилд ASEAN-ны гишүүн улсуудын ложистикийн зах зээл ихээхэн өргөжөөд байна.

Энэхүү хөгжлөөс үүдэн 2003 онд тодорхойлсон 11 тэргүүлэх салбараас гадна ложистикийн салбарын эдийн засгийн интеграцлалыг түргэсгэх 12 дахь тэргүүлэх салбар хэмээн тодорхойлсон бөгөөд дараах таван бодлогыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Логистикийн үйлчилгээг мэдэгдэхүйц либералчлах
2. Худалдаа (баримт бичгийг хялбарчлах гэх мэт) болон логистикийг (тээвэр) хөнгөвчлөх замаар ASEAN-ы логистикийн үйлчилгээ үзүүлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх
3. ASEAN-ы ложистикийн үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхийг өргөжүүлэх
4. Хүний нөөцийг хөгжүүлэх
5. Олон төрлийн тээврийн дэд бүтэц, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

MASTER PLAN ON ASEAN CONNECTIVITY 2025

Өрсөлдөх чадвар, хүртээмжтэй байдал, хамтын нийгэмлэгийг илүү их дэмжих АСЕАН-ыг тасралтгүй, иж бүрэн уялдаатай, нэгдмэл байдалд хүргэх зорилго бүхий “Master plan on asean connectivity 2025” боловсруулсан. Энэхүү бодлогын баримт бичигт “Seamless Logistics” стратегийг тусгасан байна.



СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУД ЮУ ВЭ?

- 1 АСЕАН-ы гишүүн улс бүрт нийлүүлэлтийн сүлжээний зардлыг бууруулах
- 2 АСЕАН-ы гишүүн улс бүрт нийлүүлэлтийн сүлжээний хурд, найдвартай байдлыг сайжруулах



ГОЛ САНААЧИЛГА НЬ ЮУ ВЭ?

- 1 Худалдааны зам, ложистикийг сайжруулах замаар АСЕАН-ы өрсөлдөх чадварыг бэхжүүлэх
- 2 Гол саад тотгорыг шийдвэрлэх замаар нийлүүлэлтийн сүлжээний үр ашгийг дээшлүүлэх

Энэхүү стратегийн зорилтуудад нийлүүлэлтийн сүлжээний зардлыг бууруулах, найдвартай байдлыг сайжруулах бол гол санаачилга нь АСЕАН-ы өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, нийлүүлэлтийн сүлжээний үр ашгийг дээшлүүлэх явдал байна.

Хүснэгт 1. АСЕАН-ы 2025-ын Мастер төлөвлөгөөний үр дүн ба гаралтын хэмжигдэхүүн

Strategic objectives for 2025	Outcome metrics
1. АСЕАН-ы гишүүн улс бүрт нийлүүлэлтийн сүлжээний зардлыг бууруулах	Эдийн засгийн тэргүүлэх коридороор бараа бүтээгдэхүүн тээвэрлэх зардлын хэмжээ
2. АСЕАН-ы гишүүн улс бүрт нийлүүлэлтийн сүлжээний найдвартай байдал	Эдийн засгийн тэргүүлэх коридороор бараа бүтээгдэхүүн тээвэрлэхэд зарцуулагдах хугацаа
Initiatives	Output metrics
1. Худалдааны зам, ложистикийг сайжруулах замаар өрсөлдөх чадварыг бэхжүүлэх	АСЕАН-ыг дамнасан худалдааны гол замуудын (газар болон далайн) тухай олон нийтийг тогтмол мэдээллээр хангах, мэдээллийн сан бүрдүүлэх Мэдээлэл сурталчилгааны ажил зохион байгуулах


2. Гол саад тотгорыг шийдвэрлэх замаар нийлүүлэлтийн сүлжээний үр ашгийг дээшлүүлэх	<p>Нийлүүлэлтийн гинжин хэлхээний үр ашгийн индексийг тогтоох</p> <p>Эдийн засгийн коридор бүрд дор хаяж нэг шинэчлэлийг тодорхойлсон томоохон ажлуудыг зохион байгуулах</p>
---	--

- Хэмжигдэх боломжтой
- Хөгжүүлэх шаардлагатай

ASEAN REGIONAL STRATEGY ON SUSTAINABLE LAND TRANSPORT

ТЭЭВЭР БА ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ:

Даян дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030, түүний хүрээнд дэвшүүлсэн тогтвортой хөгжлийн зорилтууд нь хэн нэгнийгээ орхилгүйгээр хөгжил дэвшилд хүрэх үлэмж том зорилгыг улс орнуудад санал болгосон билээ. Энэхүү цогц, олон талын агуулга бүхий хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр хичээнгүйлэн ажиллаж буй улс орнуудын хувьд өнөөгийн нөхцөл байдлыг илэрхийлэх баримт нотолгоо бүхий суурь үзүүлэлт гаргах, ахиц дэвшлийг хэмжих, тэргүүлэх чиглэлийг тогтоох, тэдгээрийн харилцан уялдааг хангах зорилгоор ажиллаж байна.



ASEAN-ы улс орнууд нь тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд Тогтвортой тээвэр гэсэн бодлогыг баримтлан ажиллаж байна.

Тогтвортой тээвэр нь хот, хөдөөгийн хүртээмж, хөдөө аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлэх, агаарын бохирдол, зам тээврийн ослоос үүдэлтэй эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах, цэвэр эрчим хүч, чулуужсан түлшний татаасын үр ашиггүй байдал, тэсвэрлэх чадвартай дэд бүтэц, уур амьсгалын өөрчлөлтийн арга хэмжээ, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

ASEAN-ы улс орнуудын “ТОГТВОРТОЙ ТЭЭВЭР, БҮС НУТГИЙН СТРАТЕГИ” -н 4.6-т Автотээвэр болон логистикийн талаар баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлсон байна.

4.6 НОГООН ТЭЭВЭР, ЛОГИСТИК

ASEAN-ы улс орнуудын хэрэгжүүлж буй “НОГООН ТЭЭВЭР, ЛОГИСТИК” бодлогын зорилт нь эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, тээвэрлэлтийн зардлыг бууруулах, байгаль орчинд ээлтэй ногоон тээврийг хөгжүүлэхэд чиглэсэн ажлуудыг тусгасан байна. Ногоон тээврийн бодлого, арга хэмжээг дараах гурван төрөлд ангилсан. Үүнд:

1. Логистикийн оновчлол, логистикийн төвүүд болон ачаа тээврийн биржүүдийг дэмжих
2. Хуурай замын тээврээс төмөр зам, усан зам, далайн тээвэрт шилжих горим
3. Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй ачааны тээврийн хэрэгслийг
4. Эко жолоодлого болон өөр төрлийн түлш дээр ажилладаг (LPG, gasoline), дугуйн барьцалдах чадварыг бууруулснаар хүнд даацын тээврийн хэрэгслийг ногоон болгох

2.2 Логистик, ачаа тээвэрлэлт гүйцэтгэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт

ASEAN-ы гишүүн орнуудын хоорондын авто замын ачаа тээврийн гэрээ, хэлэлцээр, улсуудын дотоодын холбогдох хууль, тогтоомж болон ASEAN-ы гишүүн бус улсуудтай хийсэн тээвэрлэлтийн гэрээ, хэлэлцээр, тунхаглал зэргийг судлан үзлээ.

2.2.1 ASEAN-ы гишүүн улсуудын гэрээ, хэлэлцээр

ASEAN-ы удирдлагууд нь Эдийн засгийн хамтын нийгэмлэг /Economic Community (AEC)/-ийг байгуулсан бөгөөд энэхүү байгууллагын нэн тэргүүний зорилт нь гааль, тээвэрлэлтийн цогц эрх зүйн орчинг бүрдүүлэх байсан бөгөөд ASEAN-ы Транзит тээврийг хөнгөвчлөх тухай суурь хэлэлцээр (AFAFGIT – Ха Ной, 1998) нь энэхүү зорилтыг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл бөгөөд есөн дээд түвшний протоколыг хэрэгжүүлэхэд чиглэсэн ерөнхий стандартыг тусгасан болно.

AFAFGIT¹-ийн зорилго нь:

- Дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийг хөнгөвчлөх, ASEAN-ы чөлөөт худалдааны бүсийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, бүс нутгийн эдийн засгийг цаашид нэгтгэхэд;
- Дамжин өнгөрөх барааг хөнгөвчлөх зорилгоор тээвэр, худалдаа, гаалийн зохицуулалт, шаардлагыг хялбарчлах, уялдуулах;
- ASEAN-д үр дүнтэй, үр ашигтай, нэгдсэн, уялдаатай транзит тээврийн системийг бий болгох.

AFAFGIT дагуух протоколууд:

- Протокол 1: Дамжин өнгөрөх тээврийн маршрут, байгууламжийг бий болгох
- Протокол 2: Хилийн пост байгуулах
- Протокол 3: Замын тээврийн хэрэгслийн төрөл, тоо хэмжээ
- Протокол 4: Тээврийн хэрэгслийн техникийн шаардлага
- Протокол 5: Авто тээврийн хэрэгслийн даатгалын ASEAN-ны схем
- Протокол 6: Төмөр замын хилийн болон уулзварын өртөө
- Протокол 7: Гаалийн дамжин өнгөрөх систем
- Протокол 8: Ариун цэврийн болон ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ
- Протокол 9: Аюултай бараа

1, 3, 4, 5 дугаар протоколууд нь Тээврийн байгууллагуудын, харин 2, 7 дугаар протоколууд нь гаалийн байгууллагын мэдэлд байна. Сингапур, Малайз, Тайланд

¹ AFAFGIT - Транзит тээврийг хөнгөвчлөх тухай суурь хэлэлцээр

улсууд AFAFGIT протоколуудыг аж үйлдвэртэй хамтран туршихын тулд туршилтыг явуулахаар тохиролцсон байна. Туршилтаар 6, 8, 9-р протоколуудыг хассан бол оруулсан протоколуудыг дараагийн шатанд хэрэгжүүлэхээр тохиролцсон байна.

2.2.2 Логистикийн үйлчилгээтэй холбоотой дотоодын зохицуулалт

ASEAN-ы арван гишүүн улсын логистик, тээврийн үйлчилгээний талаар холбогдох мэдээллийг “Логистикийн үйлчилгээ 163 дугаар тогтоол”-ын 3 дугаар зүйлд заасны дагуу цуглуулдаг бөгөөд энэхүү үр дүнд гишүүн улсуудын логистикийн үйлчилгээтэй холбоотой дотоодын зохицуулалтын жагсаалтыг гаргасан. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хүснэгтэд тусгасан болно.

Хүснэгт 2. ASEAN -ы арван гишүүн улсын логистикийн үйлчилгээтэй холбоотой дотоодын зохицуулалтууд

No.	Country	Sub-Sectors	
		International Freight Transportation excluding Cabotage	International road freight transport services
1.	Brunei	<ul style="list-style-type: none"> • Company's Act • Labour Act 	<ul style="list-style-type: none"> • Company's Act • Labour Act • Road Traffic Act
2.	Cambodia	<ul style="list-style-type: none"> • Road Traffic Law, 2017 • Investment Law, 2021 • Custom Law, 2007 	<ul style="list-style-type: none"> • Road Traffic Law, 2017 • Law on Road, 2014
3.	Indonesia	<ul style="list-style-type: none"> • Law of No. 17 of 2008 on Shipping • Law of No. 11 of 2020 on Job Creation, article 57 • Law of No. 1 of 2009 on Aviation • Law of No. 11 of 2020 on Job Creation, article 58 • Government Regulation No 31 of 2021 on Shipping, Article 13 • Presidential Regulation No 10 of 2021 on Investment Business Sector • Presidential Instruction of Rep of Indonesia No. 5 of 2005 on Empowering national shipping industry 	<ul style="list-style-type: none"> • Law of No. 22/2009 on Traffic and Road Transportation, article 139 • Government Regulation No. 30 of 2021 on Implementation of the Road Traffic and Transportation Sector
4.	Lao	<ul style="list-style-type: none"> • Road Transport Law, 1997 • Business Law, 1994 • Investment Law, 1994 	
5.	Malaysia	<ul style="list-style-type: none"> • Merchant Shipping Ordinance (MSO) 1952 • COGSA 1950 	<ul style="list-style-type: none"> • Land Public Transport Act 2010
6.	Myanmar	The Multimodal Transport Law	
7.	Philippines	<ul style="list-style-type: none"> • Presidential Decree No. 760, 866/1711 and its Implementing Rules and Regulations • Executive Order Nos. 438 and 667 • Memorandum Circular No. 182 • Republic Act No. 7471, as amended by RA No. 9301 • Republic Act No. 9295 and its Implementing Rules and Regulations 	<ul style="list-style-type: none"> • Republic Act No. 4136 The Land Transportation and Traffic Code (An Act to Compile the Laws relative to Land Transportation and Traffic Rules, to Create a Land Transportation Commission and for other Purposes). • Commonwealth Act No. 146 (The Public Service Law)

8.	Singapore	<ul style="list-style-type: none"> • Business Registration Act, Cap. 32 • Companies Act, Cap. 50 • Limited Liability Partnerships Act, Cap. 163A • Limited Partnerships Act 	<ul style="list-style-type: none"> • Business Registration Act, Cap. 32 • Companies Act, Cap. 50 • Limited Liability Partnerships Act, Cap. 163A • Limited Partnerships Act • Road Traffic Act Cap. 276
9.	Thailand	<ul style="list-style-type: none"> • Navigation in Thai Water Acts B.E. 2456 (1913) 	<ul style="list-style-type: none"> • Land Transport Act B.E. 2522 (1979)
10.	Vietnam	<ul style="list-style-type: none"> • Maritime Code, 2005. • Law on Trade, 2005. • Decree No.140/2007/ND-CP. 	<ul style="list-style-type: none"> • Law on Road traffic, 2008. • Decree No. 140/2007/ND-CP

Эх сурвалж: ASEAN member states domestic rules and regulations relevant to the logistics and transport sectoral services


2.3 ASEAN-ы ачаа, тээвэрлэлтийн өнөөгийн байдал

ASEAN-ы гишүүн улсуудын ачаа тээвэр, логистикийн асуудал болох гадаад худалдааны тэнцэл, экспорт импортын гол түнш улс орнууд, шилдэг арван бараа бүтээгдэхүүн зэргийг дараах хэсэгт судлан үзлээ.

2.3.1 Гадаад худалдааны тэнцэл, өсөлтийн хувь:

ASEAN-ы гишүүн орнууды гадаад худалдааны нийт хэмжээ 2022 онд 14.9%-иар нэмэгдэж 3846 тэрбум ам.долларт хүрч, экспорт 1962 тэрбум ам.доллар, импорт 1884 тэрбум ам.доллар байна (График 3). Энэ нь 2021 онд 25.4%-иар сэргэж эхэлсэн тогтвортой сэргэлт үргэлжилж байгааг харуулж байна.

График 1. ASEAN-ы бараа бүтээгдэхүүний экспорт, импорт, гадаад худалдааны тэнцэл (тэрбум доллар), 2005-2022



Эх сурвалж: ASEAN Key figures 2023

Малайз 58.9 тэрбум ам.доллараар гадаад худалдааны тэнцэл хамгийн өндөрт хүрсэн бол Индонез улс 54.5 тэрбум ам.доллараар удаалжээ.

График 2. ASEAN-ы гишүүн орнуудын барааны худалдааны өсөлтийн хувь (%)



Эх сурвалж: ASEAN Key figures 2023

2.3.2 Экспорт, импортын гол түнш улсууд:

ASEAN-ы экспортын хувьд (график 3) хамгийн том гадаад зах зээл нь Хятад, АНУ байсан бөгөөд тус бүр 14.8%, дараа нь Европын холбоо (9%), Япон (6.8%) байна. Импортын хувьд (график 4) Хятад улс 22.9%-иар бүс нутгийн хамгийн чухал түнш байсан бол БНСУ (7.5%), Япон (7.2%) удаалсан.

График 3. Экспорт, гол түнш улсаар, дүнд эзлэх хувь




График 4. Импорт, гол түнш улсаар, эзлэх хувь



Эх сурвалж: ASEAN Key figures 2023

2.3.3 Экспорт, импортын шилдэг арван бараа, бүтээгдэхүүн:

ASEAN-ы гишүүн орнуудын **экспортын** шилдэг арван бараа, бүтээгдэхүүний жагсаалтыг гаргасан бөгөөд 1,962,136.1 сая ам.доллар бүхий бараа бүтээгдэхүүн экспортолсноос “Цахилгаан машин, тоног төхөөрөмж, тэдгээрийн эд анги; дуу хураагч ба хуулбарлагч; телевизийн дүрс, дуу хураагч, дуу хураагчийн эд анги, дагалдах хэрэгсэл” нь 28.4% (557,575.7 сая ам.доллар)-иар жагсаалтын эхэнд бичигдсэн байна.

Хүснэгт 3. Экспортын шилдэг арван бараа, бүтээгдэхүүн

№	Бараа бүтээгдэхүүн	Үнэ (сая ам.доллар)	Хувь (%)
1	Цахилгаан машин, тоног төхөөрөмж, тэдгээрийн эд анги; дуу хураагч ба хуулбарлагч; телевизийн дүрс, дуу хураагч, дуу хураагчийн эд анги, дагалдах хэрэгсэл	557,575.7	28.4
2	Ашигт малтмалын түлш, эрдэс тос, тэдгээрийг нэрэх бүтээгдэхүүн; битумэн бодис; эрдэс лав	231,747.6	11.8
3	Цөмийн реактор, бойлер, машин механизм, механик хэрэгсэл; тэдгээрийн хэрэгслүүд	191,157.8	9.7
4	Амьтны болон ургамлын гаралтай өөх, тос, тэдгээрийн задралын бүтээгдэхүүн; малын гаралтай өөх тос; амьтны эсвэл ургамлын лав	64,664.9	3.3
5	Тээврийн хэрэгсэл; төмөр зам, трамвай замын хөдлөх бүрэлдэхүүнээс бусад эд анги, дагалдах хэрэгсэл	55,920.5	2.8
6	Хуванцар болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	53,733	2.7
7	Байгалийн тариалсан сувд; үнэт болон хагас үнэт чулуу; үнэт металл, үнэт металлаар бүрсэн металл, түүгээр хийсэн эдлэл; дуураймал үнэт эдлэл; зоос	50,722.8	2.6
8	Оптик, гэрэл зураг, кино, хэмжих, шалгах, эмнэлгийн болон мэс заслын багаж хэрэгсэл, тэдгээрийн эд анги, дагалдах хэрэгсэл	50,231.3	2.6
9	Төмөр, ган	48,123.4	2.5
10	Резин ба түүгээр хийсэн эдлэл	43,681.6	2.2
	Шилдэг 10 бараа бүтээгдэхүүний нийлбэр	1,347,558.6	68.7
	Бусад бараа бүтээгдэхүүн	614,577.5	31.3
	Нийт	1,962,136.1	100

Эх сурвалж: ASEAN Key figures 2023

Мөн **импортын** шилдэг арван бараа, бүтээгдэхүүний жагсаалтыг гаргасан бөгөөд 1,884,046.2 сая ам.доллар бүхий бараа бүтээгдэхүүн импортолсноос “Цахилгаан машин, тоног төхөөрөмж, тэдгээрийн эд анги; дуу хураагч ба хуулбарлагч; телевизийн дүрс, дуу хураагч, дуу хураагчийн эд анги, дагалдах хэрэгсэл” нь 25.7% (483,371.1 сая ам.доллар)-иар жагсаалтын эхэнд бичигдсэн байна.

Хүснэгт 4. Импортын шилдэг арван бараа, бүтээгдэхүүн

№	Бараа бүтээгдэхүүн	Үнэ (сая ам.доллар)	Хувь (%)
1	Цахилгаан машин, тоног төхөөрөмж, тэдгээрийн эд анги; дуу хураагч ба хуулбарлагч; телевизийн дүрс, дуу хураагч, дуу хураагчийн эд анги, дагалдах хэрэгсэл	483,371.1	25.7
2	Ашигт малтмалын түлш, эрдэс тос, тэдгээрийг нэрэх бүтээгдэхүүн; битумэн бодис; эрдэс лав	37,503.1	17.9
3	Цөмийн реактор, бойлер, машин механизм, механик хэрэгсэл; тэдгээрийн хэрэгслүүд	193,447.7	10.3
4	Хуванцар болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	68,285.4	3.6
5	Байгалийн тариалсан сувд; үнэт болон хагас үнэт чулуу; үнэт металл, үнэт металлаар бүрсэн металл, түүгээр хийсэн эдлэл; дуураймал үнэт эдлэл; зоос	59,753.2	3.2
6	Төмөр, ган	59,522	3.2
7	Тээврийн хэрэгсэл; төмөр зам, трамвай замын хөдлөх бүрэлдэхүүнээс бусад эд анги, дагалдах хэрэгсэл	53,444.4	2.8
8	Оптик, гэрэл зураг, кино, хэмжих, шалгах, эмнэлгийн болон мэс заслын багаж хэрэгсэл, тэдгээрийн эд анги, дагалдах хэрэгсэл	43,264.0	2.3
9	Органик химийн бодисууд	37,188.3	2.0
10	Химийн бүтээгдэхүүн	30,632.6	1.6
	Шилдэг 10 бараа бүтээгдэхүүний нийлбэр	1,366,411.9	72.5
	Бусад бараа бүтээгдэхүүн	517,634.3	27.5
	Нийт	1,884,046.2	100

Эх сурвалж: ASEAN Key figures 2023

2.3.4 Гадаадын шууд хөрөнгө оруулалт /ГШХО/-ын эх үүсвэр:

2022 онд АНУ, ASEAN, Япон, Европын холбоо (ЕХ), Хятад улс нийлээд 58.5%-тай Гадаадын шууд хөрөнгө оруулалт /ГШХО/-ын эхний 5 эх үүсвэрээр тус бүс нутагт орсон байна (Зураг 2). АНУ 36.9 тэрбум ам.доллараар тэргүүлэгч хөрөнгө оруулагч болсон нь ASEAN-ы ГШХО-ын нийт урсгалын 16.4 хувийг эзэлж байна.

Зураг 2. ASEAN-ы шилдэг 5 ГШХО эх үүсвэр, 2022 он




Эх сурвалж: ASEAN Key figures 2023

2.4 Логистикийн гүйцэтгэлийн индекс /LPI/

Логистикийн гүйцэтгэлийн индекс /LPI/ нь улс орнуудад худалдааны логистикийн үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээл, боломжуудыг тодорхойлох, гүйцэтгэлээ сайжруулахын тулд юу хийж болохыг тодорхойлоход туслах зорилгоор бүтээгдсэн интерактив жишиг хэмжих хэрэгсэл юм. LPI дэлхийн 139 улсыг харьцуулах боломжийг олгодог.

Эдгээр 139 улсыг ASEAN-ы гишүүн орон болох Сингапур 4.3 LPI оноо авч нэгдүгээр зэрэглэлд бичигдсэн байна. Малайз улс 3.6 LPI оноогоор хорин зургаадугаар зэрэглэл, Тайланд улс 3.5 LPI оноогоор гучин дөрөвдүгээр зэрэглэл, Филиппин, Вьетнам улсууд 3.3 LPI оноо тус тус авч дөчин гуравдугаар зэрэглэл, Индонез улс 3 LPI оноогоор жаран нэгдүгээр зэрэглэл, Камбож, Лаос улсууд 2.4 LPI оноогоор зуун арван тавдугаар зэрэглэлд тус тус эрэмбэлэгдсэн бол Бруней, Мянмар гэсэн хоёр улс энэхүү олон улсын жагсаалтад ороогүй байна.

График 5. Логистикийн гүйцэтгэлийн индекс /LPI/, улсаар



Эх сурвалж: www.worldbank.com

Хүснэгт 5. Зүүн Өмнөд Азийн орнуудын логистикийн гүйцэтгэлийн индекс /2023 он/

Зүүн Өмнөд Азийн орнууд	LPI зэрэглэл	Логистикийн гүйцэтгэлийн үнэлгээ	Гааль	Дэд бүтэц	Олон улсын ачаа тээвэрлэлт	Логистикийн өрсөлдөх чадвар	Ачаа тээвэрлэлийн мэдээ	Цаг хугацаа
Cambodia	115	2.4	2.2	2.1	2.3	2.4	2.8	2.7
Indonesia	61	3	2.8	2.9	3	2.9	3	3.3
LAO	115	2.4	2.3	2.3	2.3	2.4	2.4	2.8
Malaysia	26	3.6	3.3	3.6	3.7	3.7	3.7	3.7
Philippines	43	3.3	2.8	3.2	3.1	3.3	3.3	3.9
Singapore	1	4.3	4.2	4.6	4	4.4	4.4	4.3
Thailand	34	3.5	3.3	3.7	3.5	3.5	3.6	3.5
Vietnam	43	3.3	3.1	3.2	3.3	3.2	3.4	3.3

ГУРАВ. ЗҮҮН ӨМНӨД АЗИЙН ОРНУУДЫН ХОЛБОО (ASEAN)-НЫ УЛСУУДЫН ХАРИЛЦАА, ЭДИЙН ЗАСГИЙН НЭН ТААЛАМЖТАЙ НӨХЦӨЛҮҮД

3.1 Гэрээ хэлэлцээрт тусгагдсан зарчим, олгодсон эрх

ASEAN-ы гишүүн орнууд нь хоорондын бараа бүтээгдэхүүний жигд, хурдан бөгөөд үр ашигтай хөдөлгөөнийг дэмжих, улс хоорондын тээвэр болон дамжин өнгөрөх тээврийг дэмжих, хөнгөвчлөх чиглэлээр хэлэлцэн тохирч гэрээ хэлэлцээрүүдийг байгуудаг.

Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээний дагуу дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

- a. Хамгийн таатай нөхцөл: Хэлэлцэн тохирогч талууд бусад улс руу эсвэл өөр улсаас дамжин өнгөрөх тээвэрт үзүүлж буй нөхцлөөс дутуугүй таатай горимыг хэлэлцэн тохирогч бусад талын нутаг дэвсгэрт буюу нутаг дэвсгэрээс дамжин өнгөрөх тээвэрт нэвтрүүлэх;
- b. Үндэсний журам: Хэлэлцэн тохирогч талууд хэлэлцэн тохирогч бусад талын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч байсан бүтээгдэхүүнд тухайн бүтээгдэхүүнийг эх орноосоо зорьсон газар руу нь явахгүйгээр тээвэрлэсэн тохиолдолд үзүүлэхээс дутуугүй таатай горим тогтооно. бусад хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрээр дамжуулан;
- c. Тохиромжтой байдал: Хэлэлцэн тохирогч талууд хэлэлцэн тохирогч тал бүрийн хүрээнд холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, удирдлагын удирдамж болон бусад шийдвэрийг тууштай хэрэгжүүлэх
- d. Энгийн байдал: хэлэлцэн тохирогч талууд ASEAN-ы нутаг дэвсгэрт дамжин өнгөрөх тээврийн бүх журам, шаардлагыг хялбарчлахыг хичээнэ;
- e. Ил тод байдал: хэлэлцэн тохирогч талууд холбогдох эрх бүхий байгууллагад хамаарах бүх хууль тогтоомж, дүрэм журам, журам, захиргааны мэдэгдлийг шуурхай, ил тод, хүртээмжтэй байдлаар нийтэд нээлттэй болгоно;
- f. Үр ашигтай байдал: Хэлэлцэн тохирогч талууд дамжин өнгөрөх ачааны тээвэрлэлтийг хөнгөвчлөхийн тулд дамжин өнгөрөх тээврийн үр ашигтай, үр дүнтэй удирдлагаар хангана.
- g. Давж заалдах гомдол: Хэлэлцэн тохирогч талуудын холбогдох байгууллагуудын шийдвэрийг хянан шалгах үр дүнтэй механизмыг ASEAN-ы хүрээнд дамжин өнгөрөх тээврийн хэрэглэгчид болон үйлчилгээ үзүүлэгчдэд нээлттэй, хүртээмжтэй болгохыг баталгаажуулна; болон
- h. Харилцан туслалцах: Хэлэлцэн тохирогч талууд ASEAN-ы нутаг дэвсгэрт дамжин өнгөрөх барааг хөнгөвчлөхөд оролцож буй холбогдох байгууллагуудын хооронд дээд зэргийн хамтын ажиллагаа, харилцан туслалцаа үзүүлэхийг хичээнэ.

Эдгээр хэлэлцээрийн заалтыг харгалзан хэлэлцэн тохирогч талуудад дараах эрхүүдийг олгоно.

- a. Дамжин өнгөрөх тээврийн эрх
- b. Хэлэлцэн тохирогч талуудад зориулагдсан буюу тэдгээрээс ирж буй гуравдагч орны барааг ачих, буулгах эрх.

3.2 Транзит тээврийн маршрут, байгууламжийн төлөвлөгөө

Хэлэлцээрт хэлэлцэн тохирогч талууд дамжин өнгөрөх тээврийн маршрутын жагсаалтыг тусгасан бөгөөд аюулгүй байдлыг хангах үүднээс өөрийн нутаг дэвсгэрт заасан маршрутын дагуу тээврийн хэрэгслийн амрах талбайг зохих интервалаар хангаж өгсөн байна.

Хүснэгт 6. Транзит тээврийн маршруудын жагсаалт

№	Улс	АН.№	Гарал үүсэл - Очих газар
1	Бруней Даруссалам	150	Sungai Tujoh/Miri (Бруней Даруссалам / Малайз шалгах Цэг) - Куала Лурах / Лимбанг (Бруней Даруссалам/Малайз шалгах цэг)
		150	Пуни/Лимбанг (Бруней Даруссалам/Малайз шалгах Цэг) - Лабу/Лавас (Бруней Даруссалам/Малайз шалгах Цэг)
2	Камбож	1	Poi Pet (Камбож/Тайланд Хил) - Сисофон – Пномпен - Бавет (Камбож / Вьетнам хил)
		11	Trapeing Kreal (Cambodia / Lao PDR Border) - Stung Treng - Kampong Cham - Phnom Penh - Sihanoukville Port
3	Индонез	2	Мерак - Жакарта Суракарта - Сурабая - Денпасар
		150	Понтианак - Энтиконг/Тебеду (Индонез/Малайз, Саравак хил)
		25	Банда Ачех - Медан -Палембанг - Бакахуни
4	Лаос БНАСАУ	3	Ботен (БНАСАУ/Хятадын хил) - Луанг Намта - Хоуи Сай (Лаос PDR/Тайландын хил)
		12	Natrey (J.R.AH.3)-Oudomsay - Луанг Прабанг - Вьентьян
		11	Вьентьян (J.R.AH.12) - Бан Лао -Тахек - Саваннахет - Паксе - Веунхам (БНАСАУ/Камбож хил)
